

Эрдэм шинжилгээний өгүүллийн ерөнхий шаардлага

I. Бүтцийн шаардлага

- Өгүүллийн нэр
- Зохиогчийн мэдээлэл
- Товч агуулга
- Түлхүүр үг
- Удиртгал /судалгааны зорилго, асуулт, арга, хэрэглэгдэхүүн/
- Судалгааны үндсэн хэсэг
- Судалгааны үр дүн
- Дүгнэлт
- Ном зүй
- Хавсралт /шаардлагатай бол/ гэсэн хэсэгтэй байна.

Өгүүллийн нэр	Монгол, англи хэлээр, том үсгээр бичнэ. Хэмжээ: 14pt, bold
Сэтгүүлийн албан ёсны хэл	Монгол, англи хэл. Монголоор бичсэн өгүүлэл англи товч агуулгатай, англиар бичсэн өгүүлэл монгол товч агуулгатай байна. Хэмжээ: 10pt, italic
Зохиогчийн мэдээлэл	<ul style="list-style-type: none">• Овог нэрийг монгол, англи хэлээр бүтэн бичнэ.• Харьяалагдах байгууллагын нэр, зохиогчийн эрдмийн зэрэг, цол, цахим шуудангийн хаяг, ORCID дугаарыг бичих ба бусад албан тушаал, цол, гавьяа шагналыг бичихгүй. /Жишээ нь: *Доктор Ph.D, МУИС, ШУС, Хүмүүнлэгийн Ухааны Салбарын Ази судлалын тэнхим, ...@num.edu.mn, ORCID дугаар: .../• Олон зохиогчтой тохиолдолд нэг бүрийг тоон тэмдэгтээр тодорхой ялган тэмдэглэнэ. Хэмжээ: 10 pt, regular
Товч агуулга	Өгүүллийн агуулгыг товчлон 200 үгэнд багтаан англи болон монгол хэлээр бичнэ. Хэмжээ: 11pt, regular
Түлхүүр үг	5-8 түлхүүр үг хэрэглэнэ. Түлхүүр үг нь нэр үг, холбоо үг, нэрлэхийн тийн ялгал, ганц тоон дээр байна. Хэмжээ: 11pt, regular
Өгүүллийн хэмжээ	Хүснэгт, зургийн тайлбар болон ном зүйг оруулалгүйгээр /5500-аас дээш/ 9000 хүртэлх үг байна.
Үсгийн фон	<ul style="list-style-type: none">• Үндсэн өгүүлэл Times New Roman, 11pt, regular, мөр хоорондын зай 1,15 байна.• График, бүдүүвч, зургийн тайлбар Times New Roman, 10pt, regular байна.

<i>Ашигтай талбайн хэмжээ (margins)</i>	<ul style="list-style-type: none"> • А4 (210mm x 297mm) хэмжээтэй, Top 2 см, Bottom 2 см, Right 2 см, Left 3 см; мөрүүд нь баруун, зүүн талдаа зэрэгцэн бичигдэнэ. Header, footer цэс ашиглахгүй, хуудасны дугаар тавихгүй, өгүүллийн хураангуй болон түлхүүр үг хамтдаа нэг tab/догол мөр зайд бичигдэнэ. • Монгол хэлээр бичиж буй өгүүлэлд цогцолборын эхэнд догол мөр хэрэглэнэ. Мөрийн эхнээс авах догол мөрийн зай 1 см байна.
<i>Эшлэл</i>	<ul style="list-style-type: none"> • Эшлэл авсан хэсгийн ард дугуй хаалтад APA7 загвараар бичнэ. Жишээ нь: • Цахим эх сурвалжаас эшлэхдээ ямар ч тохиолдолд дан ганц сүлжээний хаяг хэрэглэхгүй ба холбоос хэт урт бол URL Shortener Link Verkürzer - hamburg.de сайтад хандан богино хэлбэрт оруулах ба сүлжээнд нэвтэрсэн он сарыг заавал бичнэ.
<i>Ном зүй</i>	<ul style="list-style-type: none"> • Ном зүйд орсон бүтээлийг монгол болон гадаад хэлээрх, цахим эх сурвалж гэсэн 3 хэсэгт, цагаан толгойн дарааллаар тус тус жагсааж дугаарлана. • Эшлэл аваагүй зохиол бүтээлийг ном зүйд оруулахгүй.

II. Агуулгад тавигдах шаардлага

1. Тус сэтгүүлд хэвлүүлэх эрдэм шинжилгээний өгүүлэл нь сэтгүүлийн бодлого чиглэлд хамаарах сэдвээр бичсэн, өмнө нь өөр сэтгүүлд хэвлэгдэж байгаагүй, судалгааны шинэлэг үр дүнг тусгасан байхын зэрэгцээ судлаачийн ёс зүйн хэм хэмжээ, үүнд тавигдах шаардлагыг хангасан байна. (МУИС-д эрдэм шинжилгээний сэтгүүл эрхлэн хэвлүүлэхэд баримтлах журамтай [NUM-erdem_shinijlgee_setquulii_juram.pdf](#) холбоосоор танилцана уу.)
2. Өгүүллийг редакцын зөвлөлийн гишүүн болон гадны байгууллагын шинжээчид давхар хянан магадалгаа хийх бөгөөд шалгуур хангахгүй гэж үзвэл зохиогчид бичгээр мэдэгдэнэ.
3. Магистрант, докторант нь өгүүлээ эрдэм шинжилгээний удирдагчийн тодорхойлолтын хамт ирүүлнэ.

III. Нийтийн хүртээл болгох

1. Үндсэн шаардлага хангасан эрдэм шинжилгээний өгүүллийг эхний хянан магадалгаа хийсний дараа сэтгүүлд хэвлэх боломжтой эсэхийг мэдээлнэ. Хянан магадалгаа хийх зардлыг өгүүллийг хүлээн авах үед авах ба зардлыг буцаан олгохгүй.
2. Нийтийн хүртээл болгох зорилгоор тухайн оны болон өмнө онуудад хэвлэгдсэн дугаарыг МУИС-ийн номын сан, улсын төв номын санд түгээдэг. Мөн [Гадаад хэл](#)

[соёл судлал \(Mongolian Journal of Foreign Languages and Cultures\) \(num.edu.mn\)](http://num.edu.mn) цахим хуудас, [Гадаад хэл соёл судлал ЭШБ](#) фэйсбүүк хуудаснаас сэтгүүлийн сүүлийн дугаарт хэвлэгдсэн өгүүллийн тухай мэдээллийг (сэтгүүлийн гарчиг, өгүүллийн хураангуй) авч болно. Сэтгүүлийн дугаараас худалдан авах хүсэлтэй бол доорх хаягаар холбогдоно уу.

Хаяг: МУИС-ийн хичээлийн 2-р байрны 403 тоот тэнхим (88024477 Л.Солонго)

Цахим хаяг: mjflc@num.edu.mn Цахим сэтгүүл: <http://journal.num.edu.mn/JOFLAC/about>

Фэйсбүүк хаяг: [гадаад хэл соёл судлал ЭШБ](#)

Холбоо барих: 99016220 (Г.Бат-Учрал), 99998023 (В.Батмаа)

“ГАДААД ХЭЛ СОЁЛ СУДЛАЛ” сэтгүүлийн редакцын зөвлөл

2024.10.04